

# ТӨРИЙН БАНКНЫ 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## 1. БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Банкны тухай
2. Онцлох ажлууд
3. Банкны дунд хугацааны зорилт
4. Дундаж давхаргыг дэмжигч банк болох зорилтын хүрээнд
  - Шинэ, онцлох бүтээгдэхүүн
  - Урамшуулалт аян, өдөрлөг, арга хэмжээ
5. Тогтвортой хөгжил

## 2. САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ



## Алсын хараа:


Дундаж давхаргыг дэмжигч, үндэсний тэргүүлэгч банк байна.

## Эрхэм зорилго:

Харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгаль орчинд ээлтэй, хүний эрхийг дээдэлсэн, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, ногоон хөгжил, дундаж давхаргыг бойжуулах, дэмжихэд чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт цахим технологи ашиглан тогтвортой, хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

## Банкны удирдлага, зохион байгуулалт:

Системийн хэмжээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 3,330 ажилтан ажиллаж байна.



## Банкны хувьцаа эзэмшигчид:



2025 оны эхний хагас жилийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн тайлангаар “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тоо 10,315 байна.

## Банк ногдол ашиг хуваарилсан тухай:

“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 32 дугаар тогтоолын дагуу 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 755,096,250 ширхэг энгийн хувьцаанд нийт 48,099,631,125 төгрөгийн ногдол ашгийг хуваарилсан.



## PCI – DSS 4.0.1 стандартыг нэвтрүүлээ

Төрийн банк төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын хамгийн сүүлийн үеийн PCI-DSS 4.0.1 (Payment Card Industry Data Security Standard) олон улсын стандартыг амжилттай нэвтрүүлж, сертификатаа гардан авлаа.



## АНУ-ын Каргил байгууллагаас 45 сая ам.долларын эх үүсвэрийг татлаа

Хөдөө аж ахуйн зээлийг дэмжих төсөлд 45 сая ам.долларыг авч нийт 115 сая ам.долларын эх үүсвэрийг амжилттай татан төвлөрүүлэв.



## “S&P Global Ratings” байгууллагаар Тогтвортой санхүүжилтийн хүрээнд үнэлгээ хийлгүүллээ.

Төрийн банк нь "S&P Global Ratings" байгууллагаар Тогтвортой санхүүжилтийн хүрээнд үнэлгээ хийлгэж, ОУ-ын ногоон бонд, нийгмийн бонд, тогтвортой хөгжилтэй уялдсан бондын зарчим болон ногоон зээл, нийгмийн зээлийн зарчмуудтай нийцсэн дүгнэлтийг амжилттай гаргууллаа.



## Төрийн банк “ТОП-100 ААН”

Топ аж ахуйн нэгжийн жагсаалтад 10 жилийн турш багтаж ирсэн Төрийн банкны тухайд, энэ удаад төрийн өмчит ТОП-10 аж ахуйн нэгжийн зургаадугаарт эрэмбэлэгдэж, амжилтын буухиагаа үргэлжлүүлээ.

## Санхүүгийн үйлчилгээ үзүүлэх



**+190,391** Иргэн **1,030.2**  
тэрбум төгрөгийн хуримтлал үүсгэлээ.



**+533,096** Зээлдэгчид **3,223**  
тэрбум төгрөгийн зээл олголоо.



**+9,685** өрхийг орон сууцтай  
болголоо.  
- ОСИЗ – 5,444  
- Орон сууцны зээл – 3,865  
- Эрчим хүчний хэмнэлттэй амины ОС зээл - 376



**+45,116** Ажлын байрыг  
хадгаллаа.

Нийт **720,564** иргэн

## Бүтээгдэхүүн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх



**129** Киоскоор  
**1,715,868** иргэнд  
үйлчилгээ үзүүллээ.



**ПОС 9,663**  
**КУБ 9,424**



**+40,028** иргэн шинээр бүртгүүлж  
**821,253** харилцагч Гялсбанк ашиглаж  
байна.



**+240,246**  
Иргэн карт шинээр  
ашиглаж байна.



Даатгалын зуучлал  
**+330,600**  
гэрээг байгууллаа.

Нийт гүйлгээний **92%** цахимаар хийгддэг боллоо.

Нийт **2,641,783** иргэн

## Санхүүгийн боловсрол, зөвлөгөө мэдээлэл хүргэх



**“БРЭНД РЕКЛАМ”**  
**2.6 сая** иргэнд мэдээлэл хүргэлээ

**22** аймаг, **4** дүүрэгт  
**“Харилцагчийн өдөрлөг”**



**+26** ЖДБ-ийг оролцуулсан  
Цуврал контент **“Амжилтын түүх”** 26  
цуврал контент - сошиал  
сувгаар **2.5 сая** хүнд



**+39,541** Бизнес эрхлэгч  
**+252,688**  
Оюутан, сурагч

Инкубатор төвийн  
харилцагч болж  
Санхүүгийн  
боловсрол олгосон.

Нийт **2,827,912** иргэн

Санхүүгийн  
зөвлөгөө,  
мэдээлэл өгсөн.

## ШИНЭ, ОНЦЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН



Банкнаас олгосон эрхийн хэмжээнд тогтоосон зээлийн лимитээр төлбөр тооцоо гүйцэтгэх, зарцуулалтаа тодорхой хугацаанд эргэн төлөх нөхцөлтэй байгууллагад зориулсан **“Байгууллагын кредит карт”** бүтээгдэхүүн, иргэнд зориулсан **“Платинум кредит карт”** бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ.



Тогтвортой хөгжилд чиглэсэн, хүн болон байгальд ээлтэй орон сууц, амины сууц худалдан авах, барих боломжтой **“Ногоон орон сууцны зээл”** бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ.



Байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийг дэмжигч иргэн, аж ахуйн нэгжид зориулсан **“Ногоон харилцах данс”** бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ.



Монгол орны өнцөг булан бүрт оршин суудаг малчид цаг хугацаа, орон зайнаас үл хамааран 100% цахимаар авах боломжтой **“Малчны цахим зээл”** бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ..



Бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, тогтвортой хөгжилд чиглэсэн бизнесийн төслүүдийг санхүүжүүлэхэд зориулан олгох **“Бизнесийн ногоон зээл”** бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ.

## УРАМШУУЛАЛТ АЯН, ӨДӨРЛӨГ, АРГА ХЭМЖЭЭ



### Кинг Тауэр тооцооны төв

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 17 дугаар хороонд шинээр нээгдсэн Төрийн банкны “Кинг Тауэр” цахим тооцооны төв албан ёсоор нээлтээ хийлээ.




“Байгальд ээлтэй Гялс цэвэрлэгээ” нөлөөллийн аяныг зохион байгуулж 8,000 гаруй га талбайгаас 1,000 орчим тонн хог хаягдал цуглуулж, хогийн цэгт төвлөрүүллээ.

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ 2025

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгууллаа.



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, “Модыг мод(а) болгоё” уриан дор “Ажилтан бүр нэг мод” зорилтот аяныг зохион байгуулж банкны 500 салбар нэгжийн 4000 ажилтан 30 гаруй нэр төрлийн 20,000 гаруй мод суулгаж, суулгац нэг бүрээ арчлан хамгаалсаар байна.



“Тогтвортой хөгжил-Ногоон ирээдүй” үзэсгэлэнг хоёр дахь жилдээ зохион байгуулж харилцагчид байгальд ээлтэй, сүүлийн үеийн, дэвшилтэт технологиудтай танилцаж, ногоон зээлүүдийг газар дээр нь судлуулснаас гадна Төрийн банкны харилцагчдад сонирхсон бүтээгдэхүүнээ тэр дор нь худалдаж авах боломжийг бүрдүүлсэн арга хэмжээг зохион байгууллаа.

## Тогтвортой санхүүжилт



**Ногоон  
зээлийн  
багц**

**86.5**

тэрбум төгрөг

Өмнөх оноос өссөн

**61.4%**

**Тогтвортой  
хөгжилд  
чиглэсэн зээл**

**240.3**

тэрбум төгрөг

Өмнөх оноос өссөн

**35.0%**

## Сургалт



ТоС холбоотой хамтран "Тогтвортой хөгжил болон санхүүжилт" сэдэвт итгэмжлэгдсэн мэргэжилтэн бэлтгэх, гэрчилгээ олгох хөтөлбөрийг зохион байгуулж, 448 ажилтныг хамрууллаа.

## Хамтын ажиллагаа, гишүүнчлэл



Монголын  
Тогтвортой  
Санхүүжилтийн  
Холбоо



НҮБ-ын Даян  
дэлхийн гэрээ



Нүүрстөрөгчийн  
нягтлан бодох  
бүртгэлийн  
санхүүгийн  
түншлэл



MUFG

Техникийн зөвлөх  
үйлчилгээний хүрээнд  
"Банкны Тогтвортой  
санхүүжилтийн хүрээ"-г  
боловсрууллаа.



Уур амьсгалын  
эрсдэлийн  
удирдлагын зөвлөх  
үйлчилгээ

## Тайлагнал



Банкны 2024 оны Тогтвортой хөгжлийн тайланд байгаль орчин, нийгэм, засаглалын үзүүлэлтүүд, тогтвортой хөгжилд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа болон цаашдын зорилтуудыг нэгтгэн олон нийтэд тайлагнан цахим хуудсанд байршууллаа.



Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлдэг БОНЗ-ын тайланг 2024 байдлаар бэлтгэж, хүргүүлсэн бөгөөд олон нийтэд нээлттэйгээр цахим хуудсанд байршууллаа.

WE SUPPORT



Нэгдсэн Үндэсний Байгууллагын Даян Дэлхийн гэрээнд банкны бизнесийн стратеги болон үйл ажиллагааг хүний эрх, хөдөлмөр, байгаль орчин, авлигын эсрэг тогтоосон 10 зарчимд уялдуулсан үүргийн хүрээнд явцын тайланг хүргүүллээ.


## Хүлэмжийн хийн ялгаруулалт




Хамрах хүрээ 1:  
**680.8 тонн CO2**

Хамрах хүрээ 2:  
**12,091.3 тонн CO2**

Хамрах хүрээ 3:  
**105,105.7 тонн CO2**



Худалдан авалт болон  
ажилтнуудын зорчих хөдөлгөөн:  
**3,642.7 тонн CO2**



Хөрөнгө оруулалт буюу зээл,  
санхүүжилт:  
**101,463.0 тонн CO2**

PCAF-ын стандартын дагуу банкны зээл, хөрөнгө оруулалт хүлэмжийн хийн ялгаруулалтыг тооцлоо.




Хүлэмжийн хийн  
шингээлт  
**1,094.2 тонн  
CO2**



Цэвэр ялгаруулалт  
**116,783.6 тонн  
CO2**

## Нийт зээл

тэрбум төгрөг



## Зээлийн багц, чанаргүй зээлийн хувь

тэрбум төгрөг




## Харилцах, хадгаламж

тэрбум төгрөг




## Нийт актив

тэрбум төгрөг



## Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа /LIQ/



## Цэвэр ашиг





# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА